

**Манж хэлний үгсийн аймагт
туслах үгийн эзлэх байр**

Энхбатын МӨНХЦЭЦЭГ¹

Монгол Улс, Улаанбаатар, Шинжлэх Ухааны Академи,
Хэл зохиолын хүрээлэн, Харьцуулсан хэл шинжлэлийн салбар

Submitted: September 25, 2025 | **Accepted:** December 29, 2025

Хураангуй: Энэхүү өгүүлэлд манж хэлний үгсийн аймгийн нэг чухал хэсэг болох туслах үгийн талаар авч үзлээ. Туслах үгсийг хэрхэн аймаглаж, ямар байдлаар тодорхойлж ирсэн талаар европын хэл шинжлэлчдийн дэвшүүлсэн гол гол ойлголт, санал дүгнэлтийг тоймлон өгүүлэв. Түүнчлэн туслах үгсийн бүрэлдэхүүн, тэдгээрийн утгын ангилал, онцлог шинжийг тодорхойллоо.

Түлхүүр үг: манж хэл, үгсийн аймаг, туслах үгийн аймаг, дагавар үг, дайвар үг, холбох үг, сул үг, аялга үг

The Position of Auxiliary Words in the Manchu Language

MUNKHTSETSEG Enkhbat

*Department of Comparative Linguistics, Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia*

Abstract: In the classification of words in any language, scholars typically rely on one of three primary criteria: semantic, morphological, or syntactic. Differences in the application of these criteria have led researchers to propose varying definitions of parts of speech, their internal classifications, and the status and position of auxiliary words. This article synthesizes the principal concepts and viewpoints advanced by Manchu linguists regarding function words.

All these studies help to establish the criteria for classifying auxiliary words in the Manchu language, to identify the characteristics of auxiliary words not only in Manchu but also in Mongolian languages, and to resolve many controversial issues in this area.

¹ © Э.Мөнхцэцэг, 2025
Email: munkhtsetsege@mas.ac.mn

Keywords: *Manchu language, part of speech, functional parts of speech, postpositions, adverbs, conjunctions, particles, interjections*

1. Удиртгал

Алтай судлалын тулгамдсан асуудлын нэг бол алтайн хэлнүүдийн хэл зүйн тогтолцоонд ач холбогдолтой болох нь маргаангүй туслах үгийн судалгаа билээ. Туслах үгс нь үгийн сангийн утгагүй, хэл зүйн хувиллаар үл хувилах ба өгүүлбэрт бие даан гишүүн болдоггүй, зөвхөн үг, өгүүлбэрийг холбох, тэдгээрийн утгыг янз бүрийн баймж утгаар чимж дэлгэрүүлэх үүрэгтэй үгс (Өнөрбаян, 2004: 313-314) юм.

Аливаа хэлний үгсийг аймаглахдаа ихэвчлэн утга зүйн зарчим, үг зүйн зарчим, өгүүлбэр зүйн зарчмын аль нэгийг голлон шалгуур хийж ангилан хуваадаг. Судлаачдын тодорхой нэг хэлний хүрээнд үгсийг аймагласан зарчмын ялгаанаас шалтгаалж үгийн аймгийн тоо, бүрэлдэхүүн, хамрах хүрээ, өөрөөр хэлбэл, үгсийг хэрхэн аймаглах тухайд нэгдмэл санал байхгүй байна. Үүнтэй адилаар манж хэлний үгсийн аймагт туслах үгийн эзлэх байрыг судлаачид янз янзаар тодорхойлжээ.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны өгүүллийг хэд хэдэн аргыг хэрэглэн бичив. Хэл шинжлэлийн хийгээд баримтад боловсруулалт хийх аргыг ашиглан манж хэлний үгсийн аймгийн тоймыг задлан шинжлэв. Судалгааны явцад түүвэрлэлтийн аргыг ашиглаж туслах үгсийн санг бүрдүүлэн, өгүүлэлд эш татах жишээ баримтын эх сурвалж болгов. Түүнчлэн харьцуулалтын аргыг түлхүү хэрэглэсэн болно.

3. Манж хэлний туслах үгийг аймагласан тойм

XVII зууны үед Францын католик шашны номлогч Жербиён «*Elementa Linguae tartaricae*» гэсэн анхны манж хэлний хэл зүйн номыг бичиж, латин хэлээр хэвлүүлсэн нь Европын эрдэмтдийн манж хэл судлах хөрс суурийг тавьжээ. Таван бүлэг бүхий энэхүү номын эхний бүлэгт манж цагаан толгойн үсэг, тэдгээрийг хэрхэн дуудах тухай өгүүлсэн. Хоёр дахь нь жинхэнэ нэр, гурав дахь нь төлөөний үг, дөрөв дэх нь үйл үгэнд зориулагджээ. Сүүлийн бүлэг нь өгүүлбэр зүйн тухай бөгөөд үүндээ туслах үйл үг, дайвар үг, угтвар үг, холбох үгсийг хамааруулсан байна (Gerbillon, 1687: 26-34). Эдгээр үгийг үндсэн үгийн аймагт оруулахаас татгалзсан нь тэдгээрийн үл хувилах онцлог, өгүүлбэрт гүйцэтгэх үүргээс шалтгаалсан бололтой.

Латин хэлний хэл зүйн бүтцийг харгалзсан өөр нэгэн бүтээл бол Германы хэл шинжлэлч Х.Габеленцийн гаргасан “Манж хэлний хэл зүйн элементүүд” (1832) юм. Энэхүү номд үгсийг 8 аймагт хуваажээ. Өөрөөр хэлбэл, холбох үг, дагавар үг, дайвар үг, аялга үгсийг бие даасан үгийн аймаг болгосон байна (Gabelentz, 1832).

Дээрх эрдэмтдээс гадна Оросын судлаач А.Владыкин², Г.М.Розов³, А.Орлов нар хэл зүйн ном зохиох оролдлогыг хийсэн байдаг (Захаров, 1879: V). Гэхдээ зөвхөн И.И.Захаров л өмнө гарсан бүтээлүүдийг нягтлан шинжилж, тэдгээрийн алдаа дутагдал болон давуу талуудыг тодруулсны эцэст, манж хэлний эртний толь бичгүүдийг ашиглан 1879 онд “Манж хэлний хэл зүй” хэмээх номоо зохиож чаджээ. Энэ бүтээл өнөөдрийг хүртэл үнэ цэнтэйд тооцогдсоор байгаа билээ.

И.И.Захаров үг бүтээх, үг хувилгах хэлбэрийг харгалзан дараах 8 үгийн аймгийг тодорхойлжээ. Үүнд, нэр үг (жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэрийг багтаагаад), төлөөний үг, үйл үг, дайвар үг, дагавар үг, холбох үг, аялга үг, сул үгс орно. Тэрээр аялга үгийн аймагт авиа дуурайх үгсийг багтааж, манж хэлэнд авиа дуурайх үг түгээмэл тохиолддогийг тэмдэглэсэн байна. Түүнчлэн энэ бүх үгийн аймгаа хэл зүйн хувьд “1) ялгалт үгс буюу жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, 2) хувилалт үгс буюу үйл үг, 3) хэл зүйн хувьд үл хувилах үгс буюу үлдсэн үгийн аймаг, сул үг” гэсэн гурван том бүлэгт хамааруулжээ (Захаров, 1879: 68-69).

Үүнээс хойш, хэдэн жилийн дараа, 1892 онд Германы эрдэмтэн П.Г.Мёлендорф манж хэлний хэл зүйн товч номыг хэвлүүлж, үгсийг нэр үг (жинхэнэ нэр, тэмдэг нэрийг багтаагаад), төлөөний үг, тооны нэр, үйл үг, дайвар үг, дагавар үг, холбох үг, аялга үгс гэсэн 8 аймагт холбогдуулсан байдаг (Möllendorff, 1892: 4-13). Нэлээд хожуу, Германы өөр нэгэн судлаач Х.Петтерс үгсийн аймгийн асуудалд тусгайлан анхаарал хандуулалгүйгээр, жинхэнэ нэр, төлөөний үг, тооны нэр, үйл үг, дайвар үг-дагавар үг-холбох үг, аялга үг, авиа дуурайх-аялга үг гэсэн ангилалд тулгуурлан манж хэлний хэл зүйн онцлогийг тодорхойлон бичжээ. Тэгэхдээ дайвар үг, дагавар үг, холбох үгийг 3 үүргээр хэрэглэж болдгоос хамаараад тэдгээрийг нэг бүлэгт багтаасан байна. Түүнчлэн авиа дуурайх-аялга үгсэд анхаарал хандуулж, тусад нь ялгаж ангилжээ (Peeters, 1940). Х.Петтерсийн энэ бүтээл ном болж хэвлэгдээгүй, зөвхөн өгүүлэл хэлбэрээр нийтлэгдсэнийг ташрамд дурдья.

Эдгээрээс гадна ойрхон зайтай хэвлэгдсэн хоёр бүтээл бий. Тэдгээрийн нэгийг 1961 онд Германы эрдэмтэн Э.Хэйниш, нөгөөг нь 1963 онд Оросын эрдэмтэн Б.К.Пашков зохиосон. Э.Хэйниш хэл шинжлэлийн үүднээс үгсийг нарийвчлан судлах гэж оролдоогүй. Зөвхөн манж эх бичвэрийг унших, сургалтад ашиглах зорилгын үүднээс зохиосон гэдгээ номынхоо оршилд тэмдэглэсэн байдаг (Haenisch, 1961: 7). Түүний номын бүтцийг харвал үгсийг 9 ангид хувааж, дайвар үг, дагавар үг, төгсгөх сул үг, туслах үйл үгийг бие даасан үгийн аймаг болгон танилцуулжээ. Хоёр дахь нь Б.К.Пашковын ном болно. Тэрээр орос хэлний уламжлалыг баримтлан манж хэлний үгсийг жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг, үйл үг, дайвар үг, дагавар үг, холбох үг, сул үг, аялга үг гэж ангилаад, хэл зүйн тодорхойлолтыг хийжээ (Пашков, 1963).

² А.Владыкины зохиосон манж хэлний товч хэл зүй нь 18 дугаар зууны сүүлчээр хэвлэгдсэн бөгөөд зөвхөн гар бичмэлээр хадгалагдан үлджээ.

³ Г.М.Розовын зохиосон «Манж хэлний хэл зүй» нь (1840 он) зөвхөн гар бичмэлээр хадгалагдан үлджээ.

В.А.Аврорины «Манж бичгийн хэл зүй» номыг хэвлүүлэгчид тус бүтээлийн оршилд, В.А.Аврорин манж хэлэнд шинэлэг бөгөөд өвөрмөц үгийн аймаг байгааг зарчмын хувьд баталж, түүнийгээ «шинж тэмдгийн нэр» гэж нэрлэсэн. Манж хэлэнд хэмжээний хувьд иххэн, чухал хэрэглээтэй, янз бүрийн шинж чанарыг илэрхийлсэн бүлэг үгс бий. Энэ нь бүхий л байдлаараа жинхэнэ нэр ба үйл үгийн дараа орох гурав дахь үгийн аймаг болно. Энэ бүлэг үгс нь утга зүй, хэл зүйн хувьд орос хэлний тэмдэг нэр, тооны нэр, дайвар үг, тодорхой хэмжээгээр төлөөний үг, зарим тохиолдолд жинхэнэ нэртэй дүйнэ гэсэн байна (Аврорин, 2000: 11-12; 97).

Түүнчлэн В.А.Аврорин авиа дуурайх үгийг аялга үгэнд хамааруулахгүй, харин «дүрслэх үг»-ийн бүлэгт багтаагаад, сул үг, дагавар үг, холбох үг, аялга үг гэсэн харилцан адилгүй үгсийг «үгсийн аймгаас гадуур үг»-ийн тоонд оруулан манж судлаачдаас өөрөөр авч үзжээ. Ингэж ангилах нь жишээлбэл, манж хэлэнд хэл зүйн хэлбэргүй нэг үгийг үйл үг, жинхэнэ нэрийн аль алинтай хэрэглэхэд шинж чанарын утга илэрхийлж (ө.х. нэг зэрэг дайвар үг, тэмдэг нэрийн аль аль нь байх), эсвэл чанарын нэр (ө.х. жинхэнэ нэр) болдгоос шалтгаалсан бололтой. Тиймээс В.А. Аврорин уламжлалт дайвар үг, тооны нэр, төлөөний үгийг «шинж тэмдгийн нэр»-д багтааж, тэдгээрээ дотор нь чанарын, харьцангуй, тооны, зэргийн, асуун заах, эс тухайлсан ерөнхийлөх, үгүйсгэх гэж нарийвчлан ангилжээ (Аврорин, 2000: 98-116).

Л.М.Горелова «Манж хэлний хэл зүй» номдоо манж хэлний үгсийг аймаглах асуудлыг хөндөж, жинхэнэ нэр ба тэмдэг нэрийн аль алиныг нэр үгийн аймагт багтааж, дараа нь тооны нэр, төлөөний үг, үйл үгийг жагсаасан байна. Үүний дараа буюу зургаа, долоодугаар бүлэгтэй дайвар үг, аялга үг ба авиа дуурайх үгийг оруулжээ. Харин дагавар үг, холбох үг, холбох төрлийн туслах үгсийг нэгтгэн «Туслах үг» гэсэн ангид багтаан наймдугаар бүлэг болгосон байна. Есдүгээр бүлэг болох бүтээвэр зүйн хэсгээ сул үгэнд зориулжээ (Gorelova, 2002: 126-380).

Дээрх мэдээллийг хүснэгтэд нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт. Манж хэлний туслах үгсийн аймгийн бүрэлдэхүүнд багтаасан үгс

	Дайвар үг	Дагавар үг	Холбох үг	Сул үг	Аялга үг	Авиа дуурайх-аялга үг	Туслах үйл үг
Ф. Жербиён	Өгүүлбэр зүй						
	+	угтвар үг	+				
Х. Габеленц	+	+	+		+		
И.И. Захаров	Хэл зүйн хувьд үл хувилах үгс						
	+	+	+	+	+		
Мёлендорф	+	+	+		+		
Э. Хэйниш	+	+		+			+
Х.Петгерс	+	+	+		+	+	
Б.К. Пашков	+	+	+	+	+		
	Шинж						

В.А. Аврорин	тэмдгийн нэр	Үгсийн аймгаас гадуур үг					
	+	+	+	+	+	+	+
Л.М. Горелова	+	Туслах үгс		+			+
		+	+				

4. Туслах үгсийн тухай ерөнхий ойлголт

Дээрх судалгааны тоймыг нэгтгэн үзвэл туслах үгсэд дайвар үг, дагавар үг, холбох үг, сул үг, аялга үгийг ямар ч эргэлзээгүй хамааруулжээ (туслах үйл үгсийг эс тооцвол). Гэхдээ ямар үгсийг аль ангилалд авч үзэх тал дээр тэр бүр санал нийлээгүй байна. Тиймээс нэг үгийг хэд хэдэн үгийн ангилалд хамааруулсан байдгийг тэмдэглүүштэй. Тухайлбал, *ele* ‘нэн’ гэсэн үгийг И.И.Захаров дайвар, эсвэл холбох үг гэсэн бол (1879: 30; 313). Л.М.Горелова зөвхөн холбох үг (2002: 359), харин В.А.Аврорин холбох үг буюу сул үг (2000: 231; 233) гэж үзсэн нь тус үгийн аймгийн олон янзын үүргийг илэрхийлжээ.

Туслах үгийн аймагт багтаасан үгс, тэдгээрийн ерөнхий онцлог шинжийг доор товч өгүүлье.

Дайвар үг. Манж хэлний дайвар үгс нь чанар, эсвэл үйлийн шинжийг заан тэмдэглэдэг үгийн аймгийг бүрдүүлдэг. Дайвар үг нь хувилдаггүй, өөрөөр хэлбэл, хэл зүйн хэлбэргүй боловч үгсийн аймгийн бие даасан үгстэй үгийн сан болон гарал үүслээр холбогдож, дайвар үг үүсгэдэг тусгай бүтээврүүдээр илэрдэг онцлогтой. Гэхдээ сүүлийнх нь заавал илрэх албагүй болно (Gorelova, 2002: 326).

Манж хэлний бүх дайвар үгийг бүтцээр нь үүсмэл, үүсмэл бус гэж хоёр хуваана. Үүсмэл бус нь ямар нэгэн үгээс үүсээгүй, дайвар үгийн үүргээр хэрэглэгддэг үгс. Үүсмэл нь жинхэнэ нэр, тэмдэг нэр, тооны нэр, төлөөний үг зэрэг өөр өөр үгийн аймгийн үгсээс бүтсэн байдаг. Жишээ нь, *te* ‘эдүгээ’, *uthai* ‘даруй, ер’, *gemu* ‘цөм’, *sasa* ‘цуг, хамт’, *cihai* ‘дураар’, *biyadari* ‘сар бүр’, *absi* ‘юутай’, *dahūn dahūn* ‘дахин дахин’ г.м.

Дайвар үгийн талаар И.И.Захаров хэл зүйн номдоо маш дэлгэрэнгүй тодорхойлсон бол (1879: 303-305), Л.М.Горелова (2002: 332-334) болон Б.К.Пашков (1963: 39-41) нарын бүтээлд дайвар үгийг утгаар нь хоёр үндсэн анги болгон ангилж, түүнийгээ дотор нь хэд хэдэн бүлэгт нарийвчлан хуваажээ. Үүнд, чанарын зэргийн дайвар үгс, үйлийн хүчийг нэмэгдүүлсэн дайвар үгс, цагийн дайвар үгс, орны дайвар үгс, байдлыг тодорхойлох дайвар үгс (батлах, заах, үгүйсгэх, хязгаарлах, таамаглах, асуух, сулхан батлах буюу үгүйсгэх) гэсэн байна.

Дагавар үг. Манж хэлний дагавар үг нь тийн ялгалуудын адил юм ба чанар, эсвэл үйлийн хоорондох харьцааг илэрхийлнэ. Гэхдээ хэл зүйн хэлбэр болж өөр үгийн аймгийг илтгэхэд хэрэглэгддэггүй, үүгээрээ бусад хэлний дагавар үгсээс ялгаатай юм (Захаров, 1879: 310).

Дагавар үгийг гарал үүслийн хувьд үүсмэл, үүсмэл бус гэсэн хоёр ангид хуваана. Үүсмэл бус зарим дагавар үгийн үүсэл гарал тодорхойгүй байдаг. Ийм үгсийн жишээнд *emgi* ‘хамт’, *gese* ‘мэт’, *jalin* ‘тул, учир’, *manggi* ‘хойно’, *sasa* ‘цуг, хамт’ гэх мэт үгс багтана. Үүсмэл нь жинхэнэ нэрээс бүтсэн дайвар үг,

эсвэл одоо цагт нөхцөл үйл үгээс бүтнэ. Жишээ нь, *dade* ‘дээр, утгаа’, *isitala* ‘хүртэл’, *songkoi* ‘ёсоор’, *dahame* ‘дагаж’ г.м. Нэмж тэмдэглэхэд, энд өгүүлсэн *gese*, *emgi*, *sasa* гэсэн үгсийг Л.М.Горелова дайвар үгийн ангилалд хамааруулсан байдаг. Тэрээр энэ тухайгаа «Манж хэлний үгс нь нэг үгийн аймгаас нөгөө рүү байнга шилжиж байдаг, ингэснээр анхны утгаа хэсэгчлэн алдаж, оронд нь тодорхой хэл зүйн утгатай болдог» (Gorelova, 2002: 345) гэж тайлбарлажээ.

Мөн түүнчлэн дагавар үгсийг утга зүйн талаас нь 1) орон зай заах дагавар үгс; 2) цаг заах дагавар үгс; 3) шалтгаан заах дагавар үгс; 4) хамтатгах дагавар үгс; 5) адилтгах дагавар үгс; 6) хэмжээ заах дагавар үгс гэсэн 6 ангид хуваасан байна (Gorelova, 2002: 347). Эдгээрийн зөвхөн эхний 3 ангилал Б.К.Пашков, В.А.Аврорин нарын бүтээлд тэмдэглэгджээ (1963: 41; 2000: 227-229).

Холбох үг. Холбох үг нь «бусад туслах үгсийн аймгийн нэгэн адил ялгалагддаггүй, хувирдаггүй, өгүүлбэрийн гишүүн болдоггүй» (Базаррагчаа., Зэгиймаа, 2014: 497). Өөрөөр хэлбэл, *geli* ‘бас’, *bime* ‘бөгөөд’, *jai* ‘жич’, *kemuni* ‘мөнхүү, үргэлж’, *embici* ‘эсвээс’, *oci* ‘болбаас’, *ofi* ‘болоод’, *aika* ‘хэрэв’, *seme* ‘хэмээвч’, *damu* ‘гагцхүү’, *ede* ‘үүнд’, *udu* ‘хэд, хэдий’ зэрэг үгсээр үг, өгүүлбэрийг өөр хооронд нь холбох үүрэгтэй туслах үгс болно.

И.И.Захаров манж хэлний холбох үгийг утгаар нь 11 хуваасан байдаг (1879: 312-313). Харин Л.М. Горелова болон В.А.Аврорин нар үүргээр нь зэрэгцсэн, захируулсан холбох үг гэсэн хоёр үндсэн бүлэгт хуваагаад тэдгээрээ дотор нь асуух, найр тавих, болзох, эсрэгцүүлэх, шалтгааны, төгсгөх, харьцуулах, нэгтгэх, салгах, цаг хугацаа ба үр дүн заах гэж нарийвчлан ангилсан (2002: 356-357; 2000: 232-236). Энэ нь И.И.Захаровын хийсэн ангиллыг (сүүлийн дөрвийг эс тооцвол) үндсэндээ давтжээ.

Сул үг. Бие даасан үг болон өгүүлбэрт нэмэлт өнгө аяс, баймж утга оруулдаг үгсийг сул үг гэнэ (Розенталь, Теленкова, 2001: 605). Манж хэлний сул үгсийг өгүүлэхүүнийг заан тодорхойлсон, үгүйсгэх, асуух, дуудах, хориглох утгатай гэж ангилна (Gorelova, 2002: 368). Үүн дээр онцлох сул үгийг Б.К.Пашков нэмсэн байдаг (1963: 43). Судлаачдын саналаас шалтгаалж зарим сул үг хэд хэдэн үгийн ангилалд багтсан тохиолдол бий. Тухайлбал, *jaka* ‘юм, завсар’ гэсэн үгийг И.И.Захаров дайвар үг (1879: 305), Б.К.Пашков дайвар үг юм уу, дагавар үг (1963: 40; 42), Л.М.Горелова холбох үг, эсвэл дагавар үг (2002: 345; 367), харин В.А.Аврорин сул үг (2000: 232) гэж үзжээ.

Аялга үг. Аливаа үйл хөдлөлд өдөөгдсөнөөс үүдэн гарах хүн ба амьтны янз бүрийн мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөн, догдлол гансралыг илэрхийлдэг бүлэг үгсийг аялга үг гэнэ (Галсан, 1975: 297). Аялга үгсийн эзлэх байрыг янз янзаар тодорхойлжээ. Тухайлбал, И.И.Захаров аялга үгийг бие даасан үгийн аймаг болгохдоо авиа дуурайх үгсийг аялга үгийн бүлэгт багтаагаад, утгаар нь 29 хэсэг ангилсан байна (1879: 315). Тэрээр «Манж хэлэнд авиа дуурайсан аялга үг маш олон, тэдгээрээр дамжин тодорхой үйл хөдлөл, нөхцөл байдалд өртсөнөөс гарах амьд биетийн мэдрэмж, сэтгэл догдлол, амьгүй биетийн хөдөлгөөнд оршин байх төлөв байдал илэрнэ» (Захаров, 1879: 315) гэжээ. Харин Б.К.Пашков аялга үгсэд дүрслэх үг, авиа дуурайх үгсийг хамааруулсан (1963: 44), Л.М.Горелова өмнө нь аялга үгэнд тооцож байсан авиа дуурайх

үгсийг бие даасан үгийн аймаг гэж үзсэн, тодруулбал, аялга үгтэй хамт эн тэнцүү үгийн аймаг болгожээ (2002: 336).

5. Дүгнэлт

Дээр өгүүлсэн манж хэлний хэл зүйн бүтээлүүдэд туслах үгсийн тухай танилцуулж, тэдгээрийн онцлог шинж, ангилал, ялгааг судлан тодорхойлохыг зорьсон байна. Түүнчлэн туслах үгс бусад үгийн аймагтай хэрхэн холбогдож байгааг илрүүлэн тодотгохыг эрмэлзжээ. Энэ бүх судалгаа нь бидний цаашдын судалгааны ажил, тодруулбал, манж, монгол хэлний туслах үгсийг харьцуулан судлах, туслах үгсийн талаарх эргэлзээтэй олон асуудлыг шийдвэрлэхэд чиг баримжаа, тулгуур хэрэглэгдэхүүн болох нь дамжиггүй билээ.

Санхүүжилт: Тус өгүүлийг ШУТС-аас санхүүжүүлж буй “Алтайн хэлнүүдийн хэл зүйн харьцуулсан судалгаа-Туслах үгийн аймгийн жишээгээр” (зөвшөөрлийн дугаар: ШуСс-2024/22) суурь судалгааны төслийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Ном зүй

- Аврорин, В.А.** (2000). *Грамматика маньчжурского письменного языка*. Санкт-Петербург. [Avrorin, V. A. *Grammar of the Written Manchu language*. Sankt-Peterburg, 2000]
- Базаррагчаа М., Зэгиймаа Ч.** (2014). *Хэл шинжлэлийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар. [Bazarragchaa M., Zegiimaa Ch. *Khel shinjileiin ner tomiyony tailbar toli* [An Explanatory Dictionary of Linguistic Terms]. Ulaanbaatar, 2014]
- Захаров, И.И.** (1879). *Грамматика маньчжурского языка*. Санкт-Петербург. [Zakharov, I. I. *Manchu grammar*. Sankt-Peterburg, 1879]
- Галсан, С.** (1975). *Сопоставительная грамматика русского и монгольского языков*. Уланбаатор. [Galsan, S. *Comparative grammar of Russian and Mongolian*]. Ulaanbaatar, 1975]
- Өнөрбаян, Ц.** (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар. [Onorbayan, Ts. *Orchin tsagyn mongol khelnii üg züi* [The morphology of Modern Mongolian]. Ulaanbaatar, 2004]
- Пашков, Б.К.** (1963). *Маньчжурский язык*. Москва. [Pashkov, B. K. *The Manchu language*. Moscow, 1963]
- Розенталь, Д.Э., Теленкова, М.А.** (2001). *Словарь-справочник лингвистических терминов*. Москва. [Rozenal, D. E., Telenkova, M. A. *Dictionary of linguistic terms*. Moscow, 2001]
- Gabelentz, H.C.** (1832). *Éléments De La Grammaire Mandchoue*. Altenbourg.
- Gorelova, L.M.** (2002). *Manchu Grammar*. Leiden-Boston-Köln.
- Haenisch, E.** (1961). *Mandschu Grammatic*. Stuttgart.
- Jerbillon, Jean-François.** (1696). *Elementa Linguae tartaricae*. Paris.

Möllendorff, P.G. (1892). *A Manchu Grammar, with Analysed Texts*. Shanghai.
Peeters, H. (1940). Manjurische Grammatik. *Monumenta Serica*. Vol. 5, No. 1/2. S.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>